

ДУНДГОВЬ АЙМГИЙН **ХӨТӨЧ НОМ**



ДУНДГОВЬ

АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймаг нь 1941 онд Өмнөговь аймгаас 8 сум, Дорноговь аймгаас 3 сум, Төв аймгаас 7 сум тус тус шилжүүлэн 18 сумтайгаар одоогийн Өлзийт сумын нутаг Ембүү дэрсэнэ ус гэдэг газар Шарангад аймаг нэртэйгээр байгуулагджээ. 1942 онд аймгийн нэрийг Дундговь хэмээн өөрчилж аймгийн төв одоогийн оршин байгаа Зоогийн Хар овооны энгэрт суурьшсан байна.

□ Аймгийн төв: Мандалговь хот

□ Сумдын тоо: 15

□ Нутаг дэвсгэрийн хэмжээ: 74,7 мянган км²

□ Хүн ам: 47104 (2019 он)

□ Үндэс Угсаатан: Халх

□ Малын тоо толгой: 3,741,111 (2020 он)


□ Утасны код: +976 (0) 159

□ Шуудангийн дугаар: 48000

□ Техникийн улсын дугаар: ДУ

□ Цахим хуудас: <http://dundgovi.gov.mn/>

Аймгийн нутаг дэвсгэрийн хилийн тойрог 1230 км, нутгийн баруун цэг Гучингийн худгаас зүүн цэг Хөх дэл хүртэл 425 км, хойд цэг Ус хар толгойгоос урд цэг Өвөр цагаан дэрс хүртэл 283 км. Нийт газар нутаг нь тал хээр говийн бүсэд багтдаг. Тэгш тал газрын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 1530 м, хамгийн нам нь 980 м, хамгийн өндөр Дэлгэрхангайн уул далайн түвшнээс дээш 1913 м өндөр өргөгдсөн байдаг. Тус аймгийн нутагт уулын хөрс /хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн/ маш бага хувийг эзэлж Адаацагийн хойд тал, Бага газрын чулуу, Угтаалын уул, Их газрын чулуу орчимд тархсан. Нутгийн төв, хойд хэсгээр ухаа толгод нам уулсын /хүрэн, цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, хээржүү цөлийн бор/ хөрс, нутгийн төв, өмнөд хэсгээр тал хөндийн /цөлөрхөг хээрийн 20 төрлийн хөрс/ хөрс тархсан.



МАНДАЛГОВЬ

ХОТЫН ТУХАЙ



Мандалговь хот нь Дундговь аймгийн төв юм. Улаанбаатар хотоос 265 км зайтай талархаг газарт д.т.дээш 1395 м өндөрт оршдог бөгөөд 11 км² талбайг эзэлдэг. Засаг захиргааны хувьд Сайнцагаан сум гэж нэрлэгдэнэ.

Өрхийн тоо: 3724

Хүн амын тоо: 12379 (2019)

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 265км



ДУНДГОВЬ АЙМГИЙН

ГОВИЙН ШУРАНХАЙ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Дундговь аймгийн “Говийн шуранхай” аялал жуулчлалын холбоо нь 2014 онд байгуулагдсан. Тус холбоо нь Дундговь аймгийн жуулчны бааз, зочид буудал эрхлэгчдийг нэгтгэж орон нутгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг сайжруулах, аялал жуулчлалын идэвхтэй үйл ажиллагааг дэмжих, мэдээллийг хүртээмжтэй хүргэх чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулах зорилготой.

Холбооны тэргүүн П.Монголмаа, Гүйцэтгэх захирлаар П. Мөнхбат, Удирдах зөвлөл нь тус аймагт үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазуудын захирал 9 гишүүнээс бүрддэг. Тус холбоо нь орон нутгийн эвент арга хэмжээ болон олон үзэсгэлэнг хамтран зохион байгуулж оролцдог.

<http://baigali.du.gov.mn/travel>

ДУНДГОВЬ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

1-р маршрут

/Түүх, соёлын өвийг үзэж танилцах /

Чиглэл нь:

Сайнцагаан сум – Сүм хөх бүрд 68 км – Бага газрын чулуу 30 км – Дэлгэрийн Чойрын хийд 15 км – Дэлгэрцогт сум 18 км – Дэрэн сум 28 км – Хайлаастын ам 6 км – Их газрын чулуу 60 км – Арагийн хад 55 км – Сайнцагаан сум 140 км.

2-р маршрут

/Байгалийн өвөрмөц тогтоц/

Чиглэл нь:

Сайнцагаан сум – Их газрын чулуу 85 км – Өөш манхан 185 км – Морин толгойн цав 48 км - Дэл уул 170 км – Цагаан суварга 35 км – Хулд 85 км – Луус 28 км – Сайнцагаан сум 55 км.

3-р маршрут

/Байгаль, түүх соёл, палентлогийн аяллын төрөл/

Чиглэл нь:

Улаанбаатар хот – Хайлаастын ам 225 км – Их газрын чулуу 60 км – Ярх уул 35 км – Өөш манхан 150 км – Дэл уул 110 км – Цагаан суварга 35 км – Хулд 75 км – Дэлгэрхангай 65 км – Онгийн хийд 90 км – Сангийн далай хийд 110 км – Сүм хөх бүрд 70 км – Бага газрын чулуу 18 км – Дэлгэрийн чойрын хийд 16 км – Дэлгэрцогт 24 км – Сайнцагаан сум – 45 км- Улаанбаатар хот 265 км.

4-р маршрут

/түүх, соёлын аялал/

Чиглэл нь:

Сайнцагаан сум – Луус 55км – Хулд сум 28 км – Дэлгэрхангай сум 65 км – Онгийн хийд 95 км – Сангийн далай хийд 120 км - Сүм хөх бүрд 70 км – Бага газрын чулуу 30 км – Чойрын хийд 18 км – Дэлгэрцогт 24 км – Сайнцагаан сум 45 км.

ҮЗМЭРҮҮД

ДУНДГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ИХ ГАЗРЫН ЧУЛУУ

Их газрын чулуу нь Мандалговиос зүүн урагш 80 километр орших байгалийн өвөрмөц тогтоц бүхий 20 орчим км үргэлжилсэн хэвтээгээр өрсөн мэт боржин чулуун бүс нутаг. 142 зүйлийн бэлчээр тэжээлийн, 53 зүйлийн эмийн ургамлууд байна. Олон төрөл зүйлийн амьтдаар баялаг энэ газар аргаль, янгир, цагаан зээр, үнэг, хярс, зэрэгтэй танилцах болно. Их газрын чулуу уулын бүсэд Тоонот, Агуйт, Эхийн умай, Рашаант зэрэг 40 гаруй агуй байдаг. Зууны манлай уртын дуучин Н.Норовбанзад, Ж.Дорждавга нарын нэрэмжит “Уяхан замбуу тивийн наран” цогцолбор дахь “Задгай театр” бий. Театрыг 2003 онд УИХ-ын 30 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авчээ. Хазаар өвс, хялгана, таана, хүмүүл, бударгана зэрэг говь хээрийн бэлчээрийн ургамал зонхилж ургахаас гадна алтан гагнуур, гичгэнэ, хунчир, далай түрүү зэрэг гучаад нэрийн эмийн ургамал ургадаг.

Алаг даага, хадны борогчин, монгол чижүүл зэрэг мэрэгчид, сахалт багваахай, жижиг соотон багваахай зэрэг гар далавчтан, тас, тас бүргэд, харцага, ногтруу, хээрийн тагтаа, болжмор зэрэг жигүүртэн аргаль, янгир, шилүүс, үнэг, хярс, тарвага, туулай зэрэг хорь гаруй төрлийн ан амьтан амьдардаг.



ҮЗМЭРҮҮД

ДУНДГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ДЭЛ УУЛ

Монголын түүх соёлын дурсгалд холбогдох хосгүй дурсгалуудын нэг бол Дэл уулын цогцолбор дурсгал юм. Дэл уул нь Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутагт орших баруунаас зүүн тийш 17км, хойноосоо урагш 8км орчим сунаж тогтсон жижиг дэл маягийн хаднуудаас бүрдэх бөгөөд урд хэсгээрээ Хөнжлийн уул, хойд хэсгээрээ Цагаан суваргатай хил залган оршино. Энэхүү уулнаа МЭӨ 3000 жилээс ХХ зууны дунд үе хүртлэх хүмүүсийн эдийн болон оюуны үнэт дурсгалууд өнөөг хүртэл хадгалагдсаар ирсэн билээ. Дэл ууланд хүрлийн үед холбогдох 3000 орчим хадны сүг зураг, эртний хүмүүсийн оромж бүхий хавтгай чулуун хашлага, 20 орчим дөрвөлжин булш, руни бичгийн дөрвөн дурсгал, Тан улсын үед холбогдох Монгол болон Хятад бичээс зэргийг нээн илрүүлсэн байна.

Монгол улсын Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор Улсын тусгай хамгаалалтанд авагдсан мөн 2008 оны 175 дугаар тогтоолоор дахин жагсаалтанд орж батлагдсан.



ҮЗМЭРҮҮД

ДУНДГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

БАГА ГАЗРЫН ЧУЛУУ

Дундговь аймгийн Адаацаг Дэлгэрцогт сумын дунд орших Бага газрын чулуу бол урт нь 15км өргөн нь 10 гаруй км үргэлжлэх боржин чулуун уул юм. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1768м өндөрт өргөгдсөн Тахилгын хавцал. Энд түүхийн янз бүрийн үед хамаарах 200 гаруй булш хиргисүүр бий. Сонин хэлбэртэй хад цохио элбэг. Бага газрын чулууны их хөндийн зүүн хойд төвд жижгэвтэр чулуун толгодын ёроолд Жаргалантын агуй бий. Жаргалантын агуйгаас 1 км орчим зайд эгц элгэн хадан дээр зориуд өрөмдсөн мэт харагдах хагас метр орчим гүн нарийнхан цооног нүхэнд хурын ус тогтсоныг нутгийнхан нүдний рашаан гэж нэрлэдэг. Сөдөтийн аманд нэгэн хийдийн туурь байх бөгөөд түүнийг Ловончомбын хийд гэдэг. Аргаль, янгирын томоохон сүрэг, уулын арын тал газарт зээрийн сүрэг бэлчдэг. Бага Газрын Чулууны зүүн өмнөдөд Гэр хад хэмээх жижгэвтэр хадан дээр хүрлийн үеийн хадны сүт зураг бий. Янгир, нум сум, хүн, нохойтой төстэй жижгэвтэр амьтныг сийлбэрлэн үлдээсэн байдаг. Түүнээс холгүй өөр нэг хаданд хоёр бугыг дүрсэлсэн байх бөгөөд 170 см урт, 90 см-ийн өргөнтэй энэ зураг аймгийн хэмжээнд томоохон олдворт тооцогддог.



ҮЗМЭРҮҮД

ДУНДГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ОНГИЙН ХИЙДИЙН ТУУРЬ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутагт Онгийн голын ус ургамал жигдэрсэн үзэсгэлэнт нэгэн тохойн зүүн эрэгт Сайхан-Овоо уулын энгэрт байдаг туурь. Онгийн хийдийг Түвдээр “Гүнджамбаалин” хийд гэдэг бөгөөд энэ нь “Хотол өглөгч” гэсэн утгатай.

Энергийн асар их төвлөрөлийн цэг нь “Онгийн хийдийн орчинд байдаг болох нь тогтоогдсон. Түүхэнд алдаршсан Онгийн гурван хийд нь Халхын Түшээт хан аймгийн Түшээ гүний хошууны нутаг Онгийн голын эрэг орчим буюу одоогийн Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг Цогт-Уул хэмээх газар оршдог. Хутагт лам Ишдоньлхүндэв, түүний шавь Дамцагдорж нар 1760-1810 оны хооронд бариулж, 1000 гаруй лам хувраг шавилан суудаг 28 сүм дугантай байжээ.

Онгийн хийдийг тойроод эргэн тойрон ууланд 5 тахилгатай овоо өдгөө үлдсэн байх бөгөөд тэдгээрийг Дөрвөлжин шашир, Бурхант шашир, Лувсан жамба, Бумбат, Сайхан-Овоо хэмээн нэрийддэг. Гэр музей нь 2001 онд байгуулагджээ. Гэр музейд нь шавь Барь лам Дамцагдоржийн зохиосон 21 боть “Сүмбум” хэмээх судар байхаас гадна өөрийнх нь хэрэглэж байсан гавлын ясан аяга, дунд чөмөгний ясаар хийсэн чөмгөн бүрээ, хийдийн лам нарын хэрэглэж байсан зэс домбо, сав суулга, лагайнамжир хэмээх хувцас хэрэглэл, балин зуурдаг модон тэвш, цай нүддэг уур нүдүүр, хүрэл тогоо тулга, мод гэх мэт.



ҮЗМЭРҮҮД

ДУНДГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

МОРИН ХУУР

Дундговь аймгийн төвийн Хар овооны Соёл амралтын хүрээлэнд 7 метр 40 сантиметр өндөртэй морин хуурыг 2007 онд бүтээн залжээ. Өргөн нь 1.5 метр бөгөөд 40 сантиметрийн зузаантай. Сийлбэрч Ө.Анхбаяр, дархан Л.Цогзол нар бүтээжээ.

Толгойг нь модоор сийлбэрлэн гаргаж, хуурын чавхдасыг төмөр троссоор, их биеийг лист төмрөөр хийж бор шаргал өнгийн боронзон будгаар буджээ. Дэлхий дахиныг хос чавхдасаараа уяруулан, байлдан дагуулсан морин хуурыг Монголчууд дээдэлдэг. Морин хуур хөгжмийг бараг мянгаад жилийн өмнөөс үүсгэсэн бөгөөд Монголчуудын тусгаар тогтнолын хамгийн том бэлгэ тэмдэг, баталгааны нэг бөгөөд 2003 оны XI сард дэлхийн өв сан болох UNESCO-д шилдэг хөгжмийн зэмсэг болгон бүртгэсэн юм.



ҮЗМЭРҮҮД

ДУНДГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

.ӨӨШ МАНХАН

Дундговь аймгийн төвөөс урагш 130 гаруй км яваад Өөш манханд хүрнэ. Хөлийн аясаар урсан нурах элсэн уулын оройд мацан гарвал оройн ирмэг хутганы ир шиг агаад хялгана ч үл хөдлөх салхигүй атал шар торгон мяндас хийсэх адил торгон элс намиатан байх аж. Элсэн уулын оройгоос загийн шугуй бүхий Өөш, Номгоны их говь, Загийн усны хоолой алсран цэлийж харагдана. Энд бөөрний сувилалын газар байдаг. Халуун элсэнд булж, ингэний сүү уулгах мэтээр бөөр нь өвчтэй хүнийг эмчилдэг. Нарны халуун энерги бүхий элс, ингэний хоормогоор дотор таван цулын хаван болон гадна хаванг эмчилдэг гэнэ. Энэ элсний "ид шид"-ийг 1978 онд анх нээсэн байна. Элсний найрлага нь их өөр бөгөөд нарийн ширхэгтэй, эрдэс баялгийн олон бодистой ажээ. Хэлнийхээ хонхорт тавихаар хайлчихдаг. Уг элсийг барилгын ажилд хэрэглэж болдоггүй юм байна. Зөвхөн бөөр, дотоод таван цул ч бус үе мөч, хөл, гар, нуруу нь татсан хүмүүс эмчлүүлэх гэж зорьдог. Элсэн эмчилгээг манай эриний өмнөх үеэс эхтэй гэж үздэг. Дээр үеийн ноёд хатад хүртэл дандаа элсэн эмчилгээ хийлгэдэг байсан гэсэн түүх байдаг.



ҮЗМЭРҮҮД

ДУНДГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ДЭЛГЭРХАНГАЙ УУЛ

Дундговь аймгийн нутагт байх Дэлгэрхангай уулыг эрт цагт Инэл хан уул гэдэг байж. Инэл гэдэг нь энгүй их, маш их, их юмны таг гэсэн утгатай үг байгаа юм. Дэлгэрхангай уулын яг орой дээр хэвлий (хэвтэш) маягийн томоос том талбай байдаг. Түүнийг Алтан тэвш гэдэг юм. Далайн түвшнээс дээш 1926 метрт өргөгдсөн түүх, домгийн өлгий нутаг. Энгэрт нь Өгөөдэй хааны ангийн отог байх төдийгүй, Тэнгэр болсон газар байдаг /хонгор хайрхан/, баруун талаар нь эртний Торгоны зам байрладаг. Дэлгэрхангай уулан дээрээс Богдхан уул, Говь гурвансайхан уул харагддагаас гадна та дурангүйгээр 200 км-ийн чанд газрыг тольдоно.



БУСАД ҮЗМЭРҮҮД



ХҮРЭЛ МОРЬ

Дундговь аймаг 2007 оны их бүтээн байгуулалтын жилийн хүрээнд “өөрийн нутгийн онцлогийг харуулах зорилгоор 2007 оны 7 сард нутгийн бренд болсон Хүрэл морийг аймгийн соёл амралтын хүрээлэнд бүтээн залсан байна. Тухайн бүтээл нь 69 см өндөртэй, 191 см урт, далавчны урт 105 см, өргөн 45 см болно. Уг морийг аймгийн сүлдээр хийсэн. Морийг жигүүртэйгээр дүрсэлсэн нь Хөхөө Намжилийн домгоос сэдвэлсэн бөгөөд дуу хуурын өлгий нутаг болохыг харуулахын тулд ийн сэдэвлэсэн. Морьны далавч 15 үзүүртэй. Энэ нь 15 сумдыг төлөөлүүлсэн. Морьны дээр мөн чандмань гурван эрднийг дүрсэлж өгсөн. Мөн морь нь өөдөө цойлж байгаагаар бүтээгджээ.

ЦАГААН СУВРАГА

Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дахь Дэл уулнаас баруун хойно орших эгц цавчим мөргөцөг. Эрт цагийн далайн ёроолын шаварлаг хурдас он цагийн эрхэнд эвдэрч эрэг ганга, мөргөцөг үүсгэсэн нь алсаас харахад цайран гэрэлтэх суварга мэт байдаг. Зүүн тийшээ харсан байдаг бөгөөд алсаас харахад байшин сууц, хот балгас мэт харагдана. Баруун талаасаа тэгш тал учир харагдахгүй. Мөргөцөгийн өндөр нь 60-аад метр бөгөөд өргөшөө нийтдээ 400-гаад метр үргэлжилдэг.

СҮМ ХӨХ БҮРД

Говийн ганц бүрд гэгдэх түүх соёлын үнэт өвийн дурсгал болсон байгалийн нэгэн үзэсгэлэнтэй газар бол Сүм хөх бүрд юм. Энэ үзэсгэлэнт бүрд Дундговь аймгийн төвөөс баруун хойш 70 км-т Адаацаг сумын нутагт Бага газрын чулуу хэмээх байгалийн үзэсгэлэнт газраас 18 км-т оршдог. Сүм хөх бүрдийн нуурын зэгсэнд орсон бод мал үзэгддэггүй, зундаа хун, галуу, ангир ирдэг байсан гэдэг. Нутгийн хөгшид нуурыг хөлгүй нуур ч гэж ярьдаг байж. Туурийн өндөр нь 7-8 метр, өргөн нь 10 метр, урт нь 25 метр. 150 сантиметрийн зузаан ханатай дөрвөн хэсэг бүхий том цайз юм. Хамгийн сонирхолтой нь энэхүү барилгыг барьсан материал нь байгалиасаа хэвлэчихсэн гэлтэй өөгүй, тэгшхэн хавтгай чулуу байдаг юм.



БУСАД ҮЗМЭРҮҮД

ЗАГИЙН УС

Загийн ус нь заган ойн ихээхэн нөөц бүхий үзэсгэлэнт газар бөгөөд шаваранцар бор хөрсөнд нь баглуурт таана, хялганат, чулуусаг алаг өвс, баглуур хялганат, бор бударганат хялганат зонхилно. Нутгийнхан заг модыг “Алтан говийн мөнгөн ой” гэж нэрлэдэг. Заг модны иш, мөчир нимгэн цагаан хальсаар бүрхэгдсэн байдаг учир “Мөнгөн ой” гэсэн ажээ. Заг нь луулийн овгийн ургамал бөгөөд Монголд зөвхөн цагаан модон заг ургадаг. Дундад Азийн нутагт хар заг, цагаан заг ургадаг ажээ. Заг хамгийн өндөртөө 8м хүрдэг боловч Монгол орны хувьд 1-3 метр өндөртэй, сөөгөн хэлбэрээр ургадаг байна. Загийн үндэс газрын гүн рүү 5 метр хүртэл сунаж ургах бөгөөд өсөж өндөрсөх тусам уртсаж 10м ч хүрэх тохиолдол байдаг байна. Загийн үндэс гол ишнээс салаалан 5-10 метр, заримдаа түүнээс ч илүү зайд тархан ургадаг. Загийн усны байгалийн цогцолбор газарт хар сүүлт бусад газраас арай илүү тоо толгойтой байдаг. Цагаан зээр, хярс, мануул, чоно, үнэг, өмхий хүрэн, шувуудаас ногтруу, хахилаг элбэг бий.



ХЭВТЭЭ БОСОО АГУЙ

Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт дахь Цагаан Суварга үзэсгэлэнт газраас зүүн тийш 7 километр, Өлзийт сумаас 85 километр орчимд намхан толгодын дунд Хэвтээ босоогийн 50 метр урт агуй бий. Агуйн зарим газар мөлхөж, зарим газар босоо явах боломжтой тул Хэвтээ босоогийн агуй хэмээн нэрлэжээ. Хэвтээ Босоогийн агуйг Цагаан Суварга руу явж байгаа хүмүүс их очиж үздэг бөгөөд Цагаан Суварга гэр баазын чанх ард байрлана. агуй хүрсэн машин замтай. Агуй нь хоёр амтай. Хойд амаар нь орвол явган сууж явах боломжтой бөгөөд цааш явсаар их танхимд орно.



МОРИН ТОЛГОЙН ЦАВ


Дундговь аймгийн Өлзийт сумын Буянт багийн нутагт байгалийн өвөрмөц тогтоц бүхий улаан шаргал өнгийн шаварлаг улаан уулыг нутгийнхан Морин толгойн цав гэдэг. Өргөрөгийн дагуу сунаж ойролцоогоор 5 орчим километр үргэлжлэн тогтсон. Эртний далайн ёроолын үлдэгдэл ажээ. Баруун хойд талаараа Өөш манхан, зүүн хойд талаараа Загийн усны бүлэг загтай зэрэгцэн орших бөгөөд урд хэсгээрээ эгц талтай.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД



БАГА ГАЗРЫН ЧУЛУУ ОРЧМЫН БААЗУУД



БАГА ГАЗРЫН ЧУЛУУ

📍 Дундговь аймгийн
Дэлгэрцогт сум

☎ 99595555
99621100

🌐 www.baigali.du.gov.mn

📄 lounge.resistors.showroom
46.3506° N, 106.1006° E



БАЯНБУЛАГ

📍 Дундговь аймгийн
Дэлгэрцогт сум

☎ 99898338
98250010

🌐 facebook.com/baynbulagcampmongolia

📄 lounge.resistors.showroom
46.1344° N, 106.1412° E



ГОВИЙН ШИНЭ ХҮРХРЭЭ

📍 Дундговь аймгийн
Дэлгэрцогт сум

☎ 99020453
93040909

🌐 [facebook.com/goviinshinekhurkhree tourist camp](https://facebook.com/goviinshinekhurkhreetouristcamp)

📄 lounge.resistors.showroom
46.1223° N, 106.0656° E

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД



БҮРД

📍 Дундговь аймгийн
Мандалговь хот

☎ 77782199

📘 Монгол, Европ, Ази хоол
www.facebook.com/burd

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



РОЯЛ

📍 Дундговь аймгийн
Мандалговь хот

☎ 99159938

📘 Монгол хоол
www.facebook.com/royal-restaurant

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



НОМУУН

📍 Дундговь аймгийн
Мандалговь хот

☎ 99116058

📘 Монгол, Европ, хүргэлт
www.facebook.com/nomuun

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E

ЭВЭНТ БАЯР НААДМУУД

МАЛЧНЫ БАЯР

Дундговь аймаг нь дуу хуур, уртын дууны өлгий нутаг төдийгүй айраг, адуугаараа Монгол түмэнд алдаршсан аймаг билээ. Энэ утгаараа Монгол айраг брендийг баталгаажуулах

ХУГАЦАА:

Жил бүрийн 9-р сард

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Сайхан овоо сум, Онгийн хийдийн байгалийн үзэсгэлэнт газар

ХӨТӨЛБӨР:

- Морьтон жагсаал
- Сайхан хувцас хэрэгсэлтэй морьтон хосыг шалгаруулах тэмцээн
- Дэмбээ шилдэг дэмбээчин шалгаруулах тэмцээн
- Морин дээрээс 4 бэрх буулгах тэмцээн
- Морин бөмбөг
- Сайхан айраг шалгаруулах, цагаан идээний үзэсгэлэн
- Бэлэг дурсгалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
- Үндэсний урлагын тоглолт
- Хуруу наадаан тэмцээн
- Сайхан монгол хувцастай аялагч жуулчин шалгаруулах тэмцээн



ИХ ГОВИЙН ТЭМЭЭ

Уг эвент арга хэмжээ нь Тэмээн сүргийн тоо толгойг өсгөх, тэмээг гадаад, дотоодод сурталчлах, тэмээн сүргээр дамжуулж, аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн болон ойролцоох сумдын тэмээчдийг уулзуулж туршлага судлах зорилгоор зохион байгуулж байгаа юм.

ХУГАЦАА:

Жил бүрийн Намар

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газар

ХӨТӨЛБӨР:

- Тэмээчдийн жагсаал
- Тэмээн поло
- Тэмээтэй сайхан хос шалгаруулах
- Тором, бүдүүн тэмээний уралдаан
- Шилмэл буур, ингэ шалгаруулах
- Ингэний сүү болон тэмээний ноосоор хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн



ЭВЭНТ БАЯР НААДМУУД

АДУУЧИН АЙРАГНЫ БАЯР

Дундговь дуу хуур, уртын дууны өлгий нутаг төдийгүй айраг, адуугаараа Монгол түмэнд алдаршсан аймаг юм

ХУГАЦАА:

Жил бүрийн 9 сард

ЭВЭНТ БОЛОХ ГАЗАР:

Дэлгэрцогт сумын Бага газрын чулуу байгалийн үзэсгэлэнт газар

ХӨТӨЛБӨР:

- Морьтон жагсаал
- Сайхан хувцас хэрэгсэлтэй морьтон хосыг шалгаруулах тэмцээн
- Дэмбээ шилдэг дэмбээчин шалгаруулах тэмцээн
- Морин дээрээс 4 бэрх буулгах тэмцээн
- Сайхан айраг шалгаруулах, цагаан идээний үзэсгэлэн
- Морь бугуйлдах, уурга шүүрэх
- Сур харвах
- Үндэсний урлагын тоглолт
- Хуруу наадаан шилдэг баг шалгаруулах тэмцээн
- Хэн сайн айраг уух вэ? тэмцээн
- Сайхан монгол хувцастай аялагч жуулчин шалгаруулах тэмцээн



УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН НААДАМ

Дундговь аймаг нь Монголдоо төдийгүй тив дэлхийд улсынхаа нэрийг цуурайтуулсан соёл, урлагийн олон арван алдартан гавьяатнуудыг төрүүлж, Монголын ард түмнээсээ “Дуу хуурын өлгий” гэсэн эрхэм хүндтэй нэр алдрыг хүртсэн тул Монгол Улсын Засгийн Газраас 2011 онд “Дуу хуур” Дундговь аймгийн брэнд бүтээгдэхүүн гэдгийг батлан өргөмжилсөн.

ХУГАЦАА:

Жил бүрийн 8 сард

ЭВЭНТ БОЛОХ ГАЗАР:

Гурвансайхан сумын Их газрын чулуу байгалийн үзэсгэлэнт газар

ХӨТӨЛБӨР:

- Гал тахих ёслол
- Морин хуур болон уртын дуучдын тоглолт
- Нар угтах ёслол
- Од тахих ёслол
- Сар тахих ёслол
- Хур гуйх ёслол
- Уул ус аргадах ёслол
- Мал сэтэрлэх болон бусад зан үйлийн тоглолтууд



ЧИГЛЭЛ:

Сайнцагаан сум – Сүм хөх бүрд 68 км – Бага газрын чулуу 30 км – Дэлгэрийн Чойрын хийд 15 км – Дэлгэрцогт сум 18 км – Дэрэн сум 28 км – Хайлаастын ам 6 км – Их газрын чулуу 60 км – Арагийн хад 55 км – Сайнцагаан сум 140 км.
Түүх, соёлын өвийг үзэж танилцах бөгөөд өтгөн ногоон зэгс бүхий говийн баян бүрд 16–17-р зууны чулуун цайз хэрэм, Их соён гэгээрүүлэгч Зава Дамдины үүсгэн байгуулсан Дэлгэрийн Чойрын хийдийн чулуун сүм дуганд өргөл үйлдэх, Бага газрын чулууны уулын байгалийн сайхан, ховор ан амьтан, ургамлыг үзэж танилцах болно. Нийт аялалын маршрут 420км.



ЧИГЛЭЛ:

Улаанбаатар хот – Мандалговь 265 км – Их газрын чулуу 85 км – Өөш манхан 185 км – Морин толгойн цав 48 км – Цагаан суварга 203 км – Мандалговь -180 км-Улаанбаатар хот 265 км.

Байгалийн өвөрмөц тогтоц бүхий эгц босоо сүрлэг хадан уулст аргаль, янгир дүүлсэн Их газрын чулуу, нар элсэн дээр доороос шарж хүний биеийн эд эсийг сэргээсэн Өөш манхан, их усан халгиж, цалгиж эрэг ганга үүсгэсэн эртний далайн ёроол мэт үзэсгэлэнт Цагаан суварга, Морин толгойн цавыг үзэж говийн онгон дагшин байгальтай танилцаж мэдрэх болно.

